



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 09 өдөр

Дугаар А/14

Булган сум

Газар ашиглах эрхийн гэрчилгээний хугацаа сунгах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 44 дүгээр зүйлийн 44.6 дахь заалт, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар баталсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 5.1.3.6 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдааны 2022 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн IX/19 дүгээр тогтоолоор баталсан "Булган сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Монголын Адвентист чуулган" шашны байгууллага /РД:1042548/-ийн гадаадын шашны байгууллагын зориулалтаар эзэмшиж буй Булган сум 5 дугаар баг Л.Энэбишийн 2 дугаар гудамж 207 тоотод байршилтай 6308007571 нэгж талбарын дугаар бүхий 1573 м² газрын газар ашиглах эрхийн гэрчилгээний хугацааг 5 жилээр сунгасугай.

2. "Монголын Адвентист чуулган" шашны байгууллагад Булган сумын шинэчилсэн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг танилцуулж, газар ашиглах эрхийн гэрээ, гэрчилгээг шинэчилж, газар ашиглалтад хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар Ү.Бямбасүрэн/-т даалгасугай.

3. Газрыг зориулалтын дагуу зүй зохистой эзэмшихийг "Монголын Адвентист чуулган"-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ

